

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	14
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.АМАРСАНАА ТАНАА

2020.03.13 № 06/843
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус ТӨААТҮГ-ын захирал Ц.Амарсанаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн барилга байгууламжийн норм, нормативын сангийн төлөвлөлт, зарцуулалт, өглөгийн дансны бүртгэл, тайлагнал, зохиогчийн хяналтын болон магадлалын хяналтын зардлын зарцуулалтын талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 27-ноос 2020 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 01/257 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь нийтийн аж ахуйн талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах, УИХ, Засгийн газраас баталсан улсын төсвийн болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд техникийн хяналт тавих, магадлал хийх ажлыг зохион байгуулах, Барилга, хот байгуулалтын яам болон эрх бүхий бусад байгууллагуудыг шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах зорилго бүхий Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот байгуулалт, барилгын салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх;
- Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах, сурталчлах хэрэгжилтийг хангах, санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, магадлал хийх иргэн хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;
- Барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж баталгаажуулах ажлыг зохион байгуулах;
- Барилга, байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индексийг боловсруулах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох;
- Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалтын ажлыг зохион байгуулах, хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцийн бодлого зорилтыг сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх;
- Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Барилгын салбарын техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;
- Барилга, нийтийн аж ахуйн салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам болон хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн Интерактив Би Ай ХХК-ийн "Diamond" программ хангамж ашиглаж байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 6,102.3 сая төгрөгөөс тооцон 122.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,045.0 сая төгрөгөөр буюу 45.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	7,096.4	12,240.3	5,143.9
Дансны авлага	32.7	33.2	0.6
Бараа материал	175.9	244.4	68.5
Үндсэн хөрөнгө	5,083.9	5,910.8	827.0
Биет бус хөрөнгө	973.4	978.5	5.1
Нийт хөрөнгийн дүн	13,362.2	19,407.2	6,045.0
Дансны өглөг	1,776.1	3,485.8	1,709.7
Урьдчилж орсон орлого	42.3	1,349.6	1,307.3
Бусад богино хугацаат өр төлбөр	1,776.4	2,615.8	839.4
Эздийн өмч	9,767.3	11,955.9	2,188.6
Өр төлбөр ба эздийн өмч	13,362.2	19,407.2	6,045.0

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, үндсэн хөрөнгө, дансны өглөг, урьдчилж орсон орлого, богино хугацаат өр төлбөр, эздийн өмч зэрэг дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө дансны үлдэгдэл 5,143.9 сая төгрөгөөр өссөн нь тухайн жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БХБЯ, ЭМЯ, БСШУСЯ-дын захиалгаар баригдаж байгаа барилга байгууламжид захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн, барилга байгууламжийн төсөвт өртгийн дүнгээс 0.18 хувиар тооцож төвлөрүүлэх норм, нормативын сангийн орлого болон барилгын материал, сорил шинжилгээний лабораторийн орлого тус тус өссөн зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 827.0 сая төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 599, 2019 оны 249 дүгээр тогтоолоор БХБЯ, ОБЕГ-аас балансаас балансад барилгын материал, сорил шинжилгээний лабораторийн хөрөнгийг шилжүүлэн авсан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу үндсэн хөрөнгийг олж бэлтгэсэнтэй холбоотой байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 1,709.7 сая төгрөгөөр өссөн нь захиалагчийн хяналтын, барилга байгууламжийн норм, нормативын сангийн, барилга байгууламжийн зураг төслийн магадлалын орлогыг өглөгт бүртгэсэн зэргээс шалтгаалжээ.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 1,307.3 сая төгрөгөөр өссөн нь барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтын төлбөр, БХБЯ-аас зарласан тендерт шалгаран хэрэгжүүлж байгаа 2 төсөл арга хэмжээний санхүүжилт, БХБЯ, ОБЕГ-аас балансаас балансад шилжүүлэн авсан барилгын материал, сорил шинжилгээний лабораторийн хөрөнгийг бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 839.4 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний зураг төслийн зохиогчид өгөх өглөгийн үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 12,955.9 сая төгрөгт хүрч өссөн нь 2,258.1 сая төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай ажилласнаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 69.6 сая төгрөгийн бичилт нь өмнөх онуудад хэрэгжүүлсэн техник хяналтын зардлыг буруу тооцсон, техник хяналтын зардлаас зохиогчид өгөх 20 хувийг өглөг үүсгэж бүртгээгүй, зарим зохиогчийн хяналтын зардлыг өглөг үүсгээгүй шууд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн 24.3 сая, ТӨБЗГ-ын 2019 оны 229 дүгээр тогтоолоор төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг 57.2 сая, нийт 81.5 сая төгрөгөөр бууруулсан, мөн зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлтээр анхны гэрээ байгуулсан төсөвт өртгийн дүн зөрүүтэй, санхүүжилтийг урьдчилж олгосон 4.6 сая, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан төлбөрийн үлдэгдэл 7.3 сая, нийт 11.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, зөрүү дүнгээр өмнөх үеийн үр дүнд өөрчлөлт оруулсан байна.

2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 599 дүгээр тогтоолоор орлогын төлөвлөгөөг 5,200.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,016.9 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Тайлант онд нийт 8,660.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 3,460.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, нийт зардалд 6,102.3 сая төгрөгийг зарцуулж төлөвлөгөөг 1,085.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Зардлын гүйцэтгэл 6,102.3 сая төгрөг буюу 121.6 хувьтай байгаа нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй нийт 487 төсөл арга хэмжээний техник хяналтыг нийслэлийн 8 дүүрэг, 21 аймагт хэрэгжүүлснээр техник хяналт хийх зардалд 448.5 сая, ТӨБЗГ-ын 2019 оны 249 дүгээр тогтоолоор БХБЯ-аас балансаас балансад шилжиж ирсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 192.1 сая, татварын шалгалтаар үл хөдлөх хөрөнгийн татварын зардалд 155.3 сая, архивын улсын үзлэг зохион байгуулсантай холбоотой архив, бичиг хэргийн

ажилтны өрөөнд хийсэн засвар, үйлчилгээний зардалд 30.9 сая, Нийгмийн даатгалын хуульд заасны дагуу ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 1 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой 29.0 сая төгрөгийг тус тус зарцуулсанаас шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн гүйцэтгэх үе шатанд 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн баталгаажуулсан болно.

Аудитаар нийт 324.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 209.9 сая төгрөгийн алдааг залруулж, 13.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 100.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа. Үүнээс:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хийгдсэн 14 их засварын ажилд зохиогч байхгүй тул 12.0 сая төгрөгийг зарцуулаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.4-т "зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилгын зураг төслийн баримт бичигт магадлал хийсэн нэр бүхий 12 эксперт нь ажил гүйцэтгэх гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, өөр байгууллагад хянах эрх шилжүүлсэн нийт 1.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг энэ хуулийн 23.2-т заасан эх загвар зураг /эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ" гэж заасантай нийцэхгүй, мөн Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 6.10-т "Эксперт магадлалын ажлын зураг төслийн холбогдох хэсгийг хүлээн авснаас хойш Барилгын тухай хуулийн 25.1-д заасан хугацаанд багтаан хийнэ" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Дээрх зөрчлийг арилгаж их засварын ажлын зохиогчийн хяналтын зардлыг тооцож санхүүжилтийг илүү олгосон, мөн магадлал хийсэн экспертүүд нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй цуцлагдсан, зарцуулаагүй нийт 13.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Тус ТӨААТҮГ-ын 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар илэрсэн норм, нормативын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, насжилт өндөртэй өглөгийн үлдэгдлийг хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох иргэн, аж ахуй нэгж байгууллагад олгоогүй зэрэг нийт 209.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

1. БХБЯ-ны 01/1713 дугаар албан бичгийн дагуу Норм, нормативын сангаас 200.0 сая төгрөгийг ШШГА-д шилжүүлж сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан,
2. БСШУСЯ-аас 2 барилгад хэрэгжүүлсэн зохиогчийн хяналтын зардлыг гүйцэтгэлээр нэхэмжилсэн дүнгээс илүү шилжүүлсэн, мөн гэрээнд заасны дагуу зарим зохиогч хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй нийт 9.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 1258 мэдээллийг хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 289.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,009.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн ба төлбөрийн акт болон зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Албан шаардлагад “БХТ ТӨААТҮГ нь сангийн хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлттэй холбоотой орлого, зардлыг анхан шатны баримт бичиг болон нягтлан бодох бүртгэлд орлого, зардлаар тусгаагүй, мөн Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор зарим чиг үүргийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т шилжүүлсэн боловч Барилгын тухай хуульд заасан “Барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах” чиг үүргийг БХТ-д шилжүүлээгүй” гэж заасныг хэрэгжүүлэхээр Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аас Норм, нормативын сангийн Удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд асуудлыг оруулсан боловч дараагийн хурлаар оруулж шийдвэрлэхээр хойшлуулсан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, стандартад нийцүүлэн материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга, аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Барилга байгууламжийн норм, нормативын сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

а. Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг журамд заагаагүй "Цаг үеийн шаардлагатай ажилд зарцуулах зардал"-д төлөвлөж, зарцуулсан,

б. Тайлант онд Норм, нормативын сангийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл хөтөлбөрт хөрөнгө зарцуулсны дараа төлөвлөгөөнд тусгахаар 2019.12.06-нд батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулжээ. Тухайлбал: Бусад зардлыг 48.2 сая төгрөгөөр өсгөж дараа онд шилжүүлэн зарцуулахаар, ББНН-ын баримт бичгийг сурталчлах, сургалт зохион байгуулах зардлыг 60.0 сая төгрөгөөр, Цаг үеийн шаардлагатай ажилд зарцуулах төсвийг 40.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөн, зарцуулсан байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8-д "Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, судлах, сурталчлах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулна", Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журмын 2.4-т "Удирдах зөвлөл нь тайлант жилдээ багтаан Сангийн үйл ажиллагааны тухайн жилийн тайланг хэлэлцэн дүгнэж, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулснаас холбогдох хууль, журам зөрчигдөх,

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, зарцуулах, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх,

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

2. *Барилга байгууламжийн норм, нормативын сангийн зарцуулалттай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт:

Барилга байгууламжийн Норм, нормативын сангаас "Төрөөс барилгын салбарын бодлогын баримт бичиг боловсруулах" төсөл арга хэмжээнд гэрээний дагуу олгох санхүүжилтээс 14.0 сая төгрөгийг илүү олгосон,

Энэ нь "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого боловсруулах" 2018/85 дугаар гэрээний тусгай нөхцөл 6.4.4-т заасныг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Батлагдсан төсөвт тусгагдаагүй зардлыг санхүүжүүлснээс холбогдох хууль, журам зөрчих,

2.3. Өгсөн зөвлөмж:

Зөвлөх үйлчилгээний төсөл арга хэмжээнд гэрээний дагуу олгох үнийн дүнгээс илүү санхүүжилт олгохгүй байх,

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

3. *Барилга байгууламжийн норм, нормативын сангийн зарцуулалттай холбоотой асуудал*

3.1. Илрүүлэлт:

Нэр бүхий 13 хэвлэл, мэдээллийн байгууллагатай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г 6-12 сарын хугацаатай байгуулж, гэрээнд гарын үсэг зурсан болон гэрээ байгуулснаас хойш 2-3 хоногт багтаан санхүүжилтийг бүрэн олгохоор заасны дагуу ажил эхлээгүй, гэрээ дүгнэсэн актгүйгээр 65.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, дансны үлгэрчилсэн заавар"-ын 7-д "... бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Санхүүжилтийг бүрэн олгосноор гэрээний үр дүн, хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх, сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

3.3. Өгсөн зөвлөмж:

Ажил гүйцэтгэх гэрээнд гарын үсэг зурсан болон гэрээ байгуулснаас хойш 2-3 хоногт багтаан санхүүжилтийг бүрэн олгохоор заасныг залруулах, ажил гүйцэтгэх гэрээний үр дүнг тооцож, ажил дүгнэсэн актаар баталгаажуулан ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байх,

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

4. Зохиогчийн хяналтын өглөгийн талаар

4.1. Илрүүлэлт:

Нэр бүхий 6 аймагт 2012-2018 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөрийн дагуу барьсан барилгуудад зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч компани болон орон нутгийн ЗДТГ-тай гэрээ байгуулсан боловч захиалагчийн хүсэлтээр зарим барилгын үе шатны ажлыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аар техникийн хяналтыг хэрэгжүүлэн, олгосон санхүүжилтээс журмын дагуу зохиогчийн хяналтын зардлыг 20 хувиар тооцон, нийт 27.5 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.4-т "зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх" гэж заасантай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

Холбогдох хууль зөрчигдөх,

4.3. Өгсөн зөвлөмж:

Зарцуулагдаагүй зохиогчийн техникийн хяналтын өглөгийн үлдэгдлийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулан шийдвэрлэх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

5. Магадлалын хяналтын өглөгийн талаар

5.1 Илрүүлэлт:

Хувийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэрээний дагуу хэрэгжүүлсэн 86.9 сая төгрөгийн 104 зураг төслийн магадлалын хяналтын ажлын холбогдох баримтын бүрдэл дутуу, гэрээг дүгнэж экспертийн цалин олгоогүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг энэ хуулийн 23.2-т заасан эх загвар зураг /эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ", ЗГ-ын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 6.10-т "Эксперт магадлалын ажлын зураг төслийн холбогдох хэсгийг хүлээн авснаас хойш Барилгын тухай хуулийн 25.1-д заасан хугацаанд багтаан хийнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам зөрчигдөх,

5.3. Өгсөн зөвлөмж:

Зураг төслийн магадлалын хяналтын ажлын холбогдох баримтын бүрдлийг хангуулах, гэрээг дүгнэж экспертийн цалин олгох асуудлыг шийдвэрлэх.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	7,304,994,887.47	12,517,915,159.42
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	7,096,387,479.20	12,240,280,880.89
1.1.2	Дансны авлага	26,715,637.31	8,247,496.57
1.1.4	Бусад авлага	5,969,200.00	24,998,600.00
1.1.6	Бараа материал	175,922,570.96	244,388,181.96
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,304,994,887.47	12,517,915,159.42
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	6,057,273,326.57	6,889,258,523.45
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,083,859,968.80	5,910,796,332.55
1.2.2	Биет бус хөрөнгө	973,413,357.77	978,462,190.90
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,057,273,326.57	6,889,258,523.45
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,362,268,214.04	19,407,173,682.87
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР	3,594,884,390.42	7,451,249,260.36
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	3,594,884,390.42	7,451,249,260.36
2.1.1.1	Дансны өглөг	1,732,262,444.75	3,251,576,419.30
2.1.1.3	Татварын өр	41,845,511.71	226,287,227.21
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,019,909.36	7,923,765.65
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	42,344,400.00	1,349,614,652.66
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,776,412,124.60	2,615,847,195.54
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,594,884,390.42	7,451,249,260.36
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,594,884,390.42	7,451,249,260.36
2.3	Эздийн өмч	9,767,383,823.62	11,955,924,422.51
2.3.1	Төрийн өмч	8,159,338.00	8,159,338.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	195,479,515.00	195,479,515.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,067,439,884.99	1,067,439,884.99
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,454,791,998.45	6,454,791,998.45
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,041,513,087.18	4,230,053,686.07
2.3.20	Эздийн өмчийн дүн	9,767,383,823.62	11,955,924,422.51
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	13,362,268,214.04	19,407,173,682.87

4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,729,895,019.80	8,226,821,416.25
2	Борлуулалтын өртөг	59,931,943.13	70,326,272.34
3	Нийт ашиг (алдагдал)	5,669,963,076.67	8,156,495,143.91
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	165,272,652.02	422,301,962.10
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	128,993,783.00	9,600,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,512,942,487.27	5,859,961,969.04
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	7,596,829.00	163,472,466.58
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,974,141.48	1,874,238.82
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,004,462,884.15)	(8,514,669.04)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	442,201,452.75	2,558,322,240.17
19	Орлогын татварын зардал	60,747,410.46	300,214,382.14
20	Татварын дараах ашиг (алдагдал)	381,454,042.29	2,258,107,858.03
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	381,454,042.29	2,258,107,858.03
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	381,454,042.29	2,258,107,858.03
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	(381,454,042.29)	(2,258,107,858.03)

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,996,421,542.09	18,566,003,619.60
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	9,418,516,114.35	15,927,076,773.88
	Бусад мөнгөн орлого	1,577,905,427.74	2,638,926,845.72
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(8,443,232,927.81)	(13,158,859,838.83)
	Ажиллагчдад төлсөн	(2,028,226,578.48)	(2,172,594,775.00)
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(953,897,748.07)	(1,186,863,325.30)
	Бараа материал худалдан авахад төлсөн	(3,890,231,254.24)	(6,597,513,002.58)
	Ашиглалтын зардалд төлсөн	(70,951,348.27)	(35,991,278.80)
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(219,156,012.97)	(1,555,018,666.15)
	Татварын байгууллагад төлсөн	(525,188,533.01)	(792,600,348.02)
	Даатгалын төлбөрт төлсөн	(4,858,630.00)	(18,958,253.00)
	Бусад мөнгөн зарлага	(750,722,822.77)	(799,320,189.98)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,553,188,614.28	5,407,143,780.77
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	165,272,652.02	422,301,962.10
	Хүлээн авсан хүүний орлого	165,272,652.02	422,301,962.10
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(224,439,735.00)	(687,426,580.00)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(224,439,735.00)	(687,426,580.00)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(59,167,082.98)	(265,124,617.90)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,231,798.43	2,138,515.58
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	3,231,798.43	2,138,515.58
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(257,656.95)	(264,276.76)
	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(257,656.95)	(264,276.76)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,974,141.48	1,874,238.82
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,496,995,672.78	5,143,893,401.69
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,599,391,806.42	7,096,387,479.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,096,387,479.20	12,240,280,880.89

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	-	5,553,814,718.45	1,802,383,532.89	7,559,837,104.34
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	-	5,553,814,718.45	1,802,383,532.89	7,559,837,104.34
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
5	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	900,977,280.00	(142,324,488.00)	758,652,792.00
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	381,454,042.29	381,454,042.29
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	1,067,439,884.99	-	-	1,067,439,884.99
9	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,067,439,884.99	6,454,791,998.45	2,041,513,087.18	9,767,383,823.62
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(69,567,259.14)	(69,567,259.14)
11	Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,067,439,884.99	6,454,791,998.45	1,971,945,828.04	9,697,816,564.48
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
13	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-
14	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	2,258,107,858.03	2,258,107,858.03
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
17	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,067,439,884.99	6,454,791,998.45	4,230,053,686.07	11,955,924,422.51

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/55/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ		сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хийгдсэн 14 их засварын ажилд зохиогч байхгүй тул 12.0 сая төгрөгийг зарцуулаагүй, 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилгын зураг төслийн баримт бичигт магадлал хийсэн нэр бүхий 12 эксперт нь ажил гүйцэтгэх гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, өөр байгууллагад хянах эрх шилжүүлсэн нийт 1.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй,	13.8	Акт тогтоох	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Амарсанаа Г.Гантуул
2	Нэр бүхий 6 аймагт 2012-2018 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөрийн дагуу барьсан барилгуудад зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч компани болон орон нутгийн ЗДТГ-тай гэрээ байгуулсан боловч захиалагчийн хүсэлтээр зарим барилгын үе шатны ажлыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аар техникийн хяналтыг хэрэгжүүлэн, олгосон санхүүжилтээс журмын дагуу зохиогчийн хяналтын зардлыг 20 хувиар тооцон, нийт 27.5 сая төгрөгийг зарцуулаагүй,	-	Зөвлөмж өгөх	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Амарсанаа Г.Гантуул

3	Нэр бүхий 13 хэвлэл, мэдээллийн байгууллагатай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г 6-12 сарын хугацаатай байгуулж, гэрээнд гарын үсэг зурсан болон гэрээ байгуулснаас хойш 2-3 хоногт багтаан санхүүжилтийг бүрэн олгохоор заасны дагуу ажил эхлээгүй, гэрээ дүгнэсэн актгүйгээр 65.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй,	-	Зөвлөмж өгөх	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Амарсанаа Г.Гантуул
4	Барилга байгууламжийн Норм, нормативын сангаас "Төрөөс барилгын салбарын бодлогын баримт бичиг боловсруулах" төсөл арга хэмжээнд гэрээний дагуу олгох санхүүжилтээс 14.0 сая төгрөгийг илүү олгосон,	14.0	Зөвлөмж өгөх	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Амарсанаа Г.Гантуул
5	а. Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг журамд заагаагүй "Цаг үеийн шаардлагатай ажилд зарцуулах зардал"-д төлөвлөж, зарцуулсан, б. Тайлант онд Норм, нормативын сангийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, зардлыг зарцуулсны дараа төлөвлөгөөнд тусгахаар 2019.12.06-нд батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал: Бусад зардлыг 48.2 сая төгрөгөөр өсгөж дараа онд шилжүүлэн зарцуулахаар, ББНН-ын баримт бичгийг сурталчлах, сургалт зохион байгуулах зардлыг 60.0 сая төгрөгөөр, Цаг үеийн шаардлагатай ажилд зарцуулах зардлыг 40.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөн, зарцуулсан,	-	Зөвлөмж өгөх	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Амарсанаа Г.Гантуул
6	Хувийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэрээний дагуу хэрэгжүүлсэн 86.9 сая төгрөгийн 104 зураг төслийн магадлалын хяналтын ажлын холбогдох баримтын бүрдэл дутуу, гэрээг дүгнэж экспертийн цалин олгоогүй байна.	86.9	Зөвлөмж өгөх	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Амарсанаа Г.Гантуул
	Дүн	114.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2019 оны 11 дугаар сарын 25

№ 05/105

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолын дагуу Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 байгууллагад өмнөх онуудад хийгдсэн их засварын ажлын техник хяналтын зардалд захиалагч болон зохиогчийн хяналтын зардлыг тооцож санхүүжилтийг олгосон ба зохиогч байхгүй тул зохиогчийн хяналтын гэрээ хийгдээгүй 11,962,443.00 төгрөгийг зарцуулаагүй тул өглөгт бүртгэсэн,
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилгын зураг төслийн баримт бичигт магадлал хийсэн нэр бүхий 12 эксперт нь ажлын гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, өөр байгууллага руу хянах эрх шилжсэн зэрэг шалтгаанаар гэрээ цуцлагдсан 1,864,545.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг энэ хуулийн 23.2-т заасан эх загвар зураг /эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ", 38 дугаар зүйлийн 38.1.4-т "зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх", Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 6.10-т "Эксперт магадлалын ажлын зураг төслийн холбогдох хэсгийг хүлээн авснаас хойш Барилгын тухай хуулийн 25.1-д заасан хугацаанд багтаан хийнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчлийг арилгаж засварын ажлын зохиогчийн хяналтын зардлыг тооцож илүү олгосон санхүүжилт, мөн магадлал хийсэн экспертүүд нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тул цуцлагдсан зэрэг нийт 13.8 сая төгрөгийг 2019 оны 12 дүгээр сарын 2-ны өдрийн дотор Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Тогтоосон төлбөрийн актыг барагдуулж, биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал Ц.Амарсанаа, ерөнхий нягтлан бодогч Г.Гантуул нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
 АУДИТОР *В.Н* Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТОР *О.Б*
 О.БАЯРМАА

АКТ

ЗӨВШӨӨРСӨН:
 БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН
 ЗАХИРАЛ *Ц.А*
 БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН
 ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 Г.ГАНТУУЛ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил зургасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь алгах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kherel\Akt\2019\11255461.Docx

070364

